



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/377

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 05/06 дугаар тогтоолын хавсралтын 5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 05/06 дугаар тогтоолын хавсралтын 5 дахь заалтад тусгагдсан Хужирт сумын төрийн албан хэрэгцээний байр барих зардал 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Хужирт сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнахыг сумын Засаг дарга (Т.Баярмөнх)-д үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100795